



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/375

Зуунмод

Засаг даргын нэрэмжит гамшгаас
хамгаалах бэлэн байдлын үзлэгийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/315 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын хэмжээнд стратегийн команд штабын сургуулийг зохион байгуулах болсонтой холбогдуулан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд аймгийн гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах зорилгоор "Аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг"-ийг зохион байгуулахыг Онцгой байдлын газар (хурандаа Н.Төмөрбаатар)-т даалгасугай.

2.Аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт хамрагдах албад, мэргэжлийн ангийн нэрсийг нэгдүгээр, бэлэн байдлын үзлэг явуулах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах чиглэлээр бэлтгэлийг ханган үзлэгт хамрагдахыг албад, мэргэжлийн ангийн дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123010914

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 05 -ны өдрийн 4/375 дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ БЭЛЭН БАЙДЛЫН
ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ ОРОН НУТГЫН АЛБА, МЭРГЭЖЛИЙН АНГИ,
АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

д/д	Аймгийн гамшгаас хамгаалах алба	Хариуцах байгууллага	Удирдах албан тушаалтан
1.	Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээлэх алба	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Ж.Даш-Яйчил
2.	Эрүүл мэндийн алба	Эрүүл мэндийн газар	С.Мөнхтуяа
3.	Хүнс, хөдөө аж ахуйн алба	Хүнс хөдөө аж ахуйн газар	Н.Гантулга
4.	Түлш, эрчим хүчээр хангах алба	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	Д.Саран-Эрдэнэ
5.	Хэв журам сахиулах алба	Төв аймаг дахь Цагдаагийн газар	Ч.Алтанхуяг
6.	Мэдээлэл, харилцаа холбооны алба	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв	С.Цогбаяр
7.	Зам, тээврийн алба	Авто тээврийн төв	Н.Аасүрэн
8.	Барилга хот байгуулалтын алба	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	Б.Насанжаргал
9.	Хүн ам, нийгмийн хамгааллын алба	Нийгмийн бодлогын хэлтэс	Д.Мөнхцэцэг
10.	Мал эмнэлгийн алба	Мал эмнэлгийн газар	Б.Болдбаатар

Тусгай зориулалттай мэргэжлийн анги

д/д	Мэргэжлийн ангийн нэр	Бүлэг	Хариуцсан байгууллагын нэр
1	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүлэг	7	Аймгийн Нэгдсэн эмнэлэг
2	Хүүхэд хамгаалал, боловсролын бүлэг	2	Боловсрол шинжлэх ухааны газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
3	Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах бүлэг	2	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс
4	Иргэний бүртгэл, мэдээллийн бүлэг	1	Улсын бүртгэлийн хэлтэс
5	Статистик мэдээллийн бүлэг	1	Статистикийн хэлтэс
6	Хэв журам сахиулах бүлэг	1	Төв аймаг дахь Цагдаагийн газар
7	Тусгай бүлэг	1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
8	Санхүү, нөөцийн бүлэг	1	Аймгийн Засаг даргын Тамгын газар
9	Хүнсний хангалтын бүлэг	1	
10	Орон байр, хувцас хангалтын бүлэг	1	Биеийн тамир, спортын газар
		1	Соёл, урлагын газар
11	Тээврийн бүлэг	1	Авто тээврийн төв
12	Шатахуун, хийн түлш хангалтын бүлэг	1	Зуунмод суманд байрлах шатахуун түгээх станцууд

13	Нүүлгэн шилжүүлэлт, түр байрны бүлэг		1	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
14	Хоргодох байрны бүлэг		1	
15	Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн бүлэг		1	Мал эмнэлэгийн газар
16	Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүлэг		1	
17	Ургамал, газар тариалан хамгаалах бүлэг		1	Хүнс, хөдөө аж ахуйн газар
18	Уст цэг хамгаалах бүлэг		1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
19	Дулааны шугам сүлжээний засварын бүлэг		1	"Төв Чандмань" ДЭХГазар
20	Цахилгаан, шугам сүлжээний засварын бүлэг		1	
21	Цахилгаан, шугам сүлжээний засварын бүлэг		1	УБЦТС ТӨХК-ны ашиглалт, засварын Зуунмод төв
			1	УБЦТС ТӨХК-ны Зуунмод хэрэглэгчдэд үйлчлэх төв
22	Зам, гүүрийн засварын бүлэг		1	"Төв АЗЗА" ТӨХК
23	Инженер, тэсэлгээний бүлэг		1	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл
24	Харилцаа холбоо, зарлан мэдээллийн бүлэг		1	МХС ТӨХК-ийн Төв аймаг дахь холбооны газар
			1	Монголын цахилгааны холбоо ТӨХК-ийн Төв аймаг дахь газар
			1	Зуунмод сум дахь үүрэн холбооны салбарууд
25	Мэдээлэл, сурталчилгааны бүлэг		1	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв
				ТӨВ телевиз
				TBS телевиз
26	Хуулийн этгээдийн мэргэжлийн анги	Анхны тусламжийн нөхөрлөл	1	Стандарт, хэмжил зүйн хэлтэс
		Аврах, гал унтраах бүлэг	1	
		Ухуулга, сурталчилгааны бүлэг	1	
27	Гал түймэр унтраах, аврах бүлэг		1	Гал түймэр унтраах, аврах 24-р анги
			1	Эрэн хайх, аврах салбар
28	Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бүлэг		1	Онцгой байдлын газрын харьяа 07 дугаар анги
29	Олон Улсын хүмүүнлэгийн тусламжийн бүлэг		1	Улаан загалмайн хороо

___oOo___

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 05-ны өдрийн 11375 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

**"АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ГАМШГААС ХАМГААЛАХ
БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ" ЯВУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг.Зорилго

Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэлийг хангах, албад, мэргэжлийн анги, байгууллага аж ахуйн нэгжийн гамшигтай тэмцэх бэлэн байдлыг дээшлүүлж, Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахад чиглэгдэнэ.

**Хоёр.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын
үзлэгт хамрагдах байгууллага**

- 1.Гамшгаас хамгаалах орон нутгийн 10 албад, 29 мэргэжлийн анги.
- 2.Зуунмод сумын Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги.

Гурав. Бэлэн байдлын үзлэгийн чиглэл

1. Мэргэжлийн ангийн гишүүдийг томилгоожилт;
2. Албад, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний аранзны бэлэн байдал;
3. Аюулт үзэгдэл, ослын үед ажиллах автомашин, механизм, багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийг томилгоожуулсан байдал;
4. Барилга, байгууламжийн ойролцоо аюулгүйн талбай /цугларах цэг/ тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан байдал.

Дөрөв. Үзлэг зохион байгуулах хугацаа

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 2 үе шаттай зохион байгуулах бөгөөд урьдчилсан үзлэгийг 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 11:00 цагт, нэгдсэн үзлэгийг 06 дугаар сарын 08-ны өдрийн 16:00 цагт тус тус зохион байгуулна.

Урьдчилсан болон нэгдсэн үзлэгийг Зуунмод сумын Мөнх-Алдарын талбайд зохион байгуулна.

Тав. Үзлэг явуулах ажлын хэсэг

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн удирдагч:	Н.Төмөрбаатар	Онцгой байдлын газрын дарга, хурандаа
Үзлэг явуулах бүрэлдэхүүн:	Г.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа
	Л.Нямдаваа	Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хошууч
	Б.Цэрэнхүү	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад
	Д.Мөнхбаатар	Холбоо зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч
	Д.Бадамсамбуу	Гал түймэр унтраах аврах 24 дүгээр ангийн захирагч, ахмад

Зургаа.Үзлэгийн үр дүнг тооцох

"Аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг"-ийг дүнг аймгийн Засаг даргад танилцуулж, үзлэгт хангалтгүй шалгагдсан алба, мэргэжлийн ангийн удирдлагад холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцон зөрчил дутагдлыг нэн даруй арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

___оОо___



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/376

Зуунмод

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг
хязгаарлаж, хяналт тавих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 7.11, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын хэмжээнд зарим аймагт хонины цэцэг, бог малын мялзан өвчин, манай аймгийн Баянжаргалан суманд бог малын мялзан өвчин, Баянцагаан, Баянцогт, Баянжаргалан суманд хонины цэцэг өвчин бүртгэгдэн хорио цээрийн дэглэм тогтоож байгаатай холбогдуулан тус өвчин дамжин тархах эрсдэлээс сэргийлэх зорилгоор гадны аймаг сумаас болон аймгийн сум хооронд бог малын шилжилт хөдөлгөөнийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл түр хугацаагаар хориглосугай.

2.Орон нутгийн хэмжээнд гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, угаалга, халдваргүйтгэлийн ажлыг эрчимжүүлэн, амьд малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулж, бэлэн байдлыг ханган ажиллах, зайлшгүй шаардлагаар отор нүүдлээр ирсэн бог малыг хүлээж авахдаа сумын хилийн цэс дээр үзлэг хийн, угаалгад хамруулан 14 хонгийн хугацаанд тусгаарлаж тухайн бүс нутагт оруулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Малчдад гоц халдварт, халдварт өвчний талаар мэдээлэл өгч, хариуцлагажуулж, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (Б.Болдбаатар)-д, мал эмнэлгийн гэрчилгээгүй отор нүүдэл, үржлээр амьд мал тээвэрлэсэн тохиолдолд зохих арга хэмжээг авч ажиллахыг Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг)-т, гадны аймаг сумаас үржлийн зориулалттай амьд мал авах, сумдад тараахдаа хамрагдсан мал эмнэлгийн арга хэмжээ, тусгаарласан эсэх, дэгдэлттэй байгаа өвчний шинжилгээ өгсөн эсэхийг нягтлан холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Н.Гантулга) нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

1123010969
Муг.Доc.зaхирaмж-2023-2.01101



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/377

Зуунмод

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5, 17 дугаар зүйлийн 17.2.2, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2, 20.1.3, 20.1.4, 20.1.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 23-2947, 23-3649, 23-3819, 23-3833 тоот дээжийн хариуг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Мал эмнэлгийн газрын саналыг үндэслэн гоц халдварт "Хонины цэцэг" өвчин оношлогдсон Баянцагаан, Баянжаргалан, Баянцогт сум, "Бог малын мялзан" өвчин оношлогдсон Баянжаргалан суманд сүүлчийн өвчилсөн мал эдгэрч сүрэгт нийлүүлснээс хойш 21-30 хоногоор хугацааг тооцон хорио цээрийн дэглэмийг тогтоосугай.

2.Гоц халдварт Бог малын мялзан, Хонины цэцэг өвчин оношлогдсон сумдыг шуурхай удирдлага зохион байгуулалтаар ханган, халдварын хүрээ, голомтын бүсийн хилийн цэсийг тогтоох арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (Б.Болдбаатар)-д даалгасугай.


3.Хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд хүн, мал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглож, хорио цээрийн бүсээс гадагшаа дур мэдэн нүүдэл хийсэн малчин, мал бүхий иргэнийг хуулийн дагуу арга хэмжээ авч, хариуцлага тооцон ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (Ч.Алтанхуяг)-д үүрэг болгосугай.

4.Гамшгаас хамгаалах хуулийн дагуу сумдын мэргэжлийн ангийг бүрэн бие бүрэлдэхүүнээр ажиллуулж, хорио цэрийн дэглэмийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үүрэг чиглэл өгч, хяналт, шалгалт хийж, удирдлагаар ханган ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга (Н.Төмөрбаатар)-д үүрэг болгосугай.

5.Хорио цээрийн дэглэмийн үйл ажиллагааг Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын дагуу үр дүнтэй зохион байгуулж, халдвар тархаахгүйгээр хүн, мал, амьтан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн хориглон, малчин, мал бүхий иргэдийг мэдээллээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

6.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

1123010966
MyDocZabranj 2023-10-01



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/384

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Дуламжав нь бага дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу Ерөнхий боловсролын сургуулийн захирлын нийтлэг эрх, үүрэг шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Нарантуяа (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Гишүүд:

Т.Идэр (Албан бус насан туршийн боловсролын төвийн захирал)

Б.Дашцэрмаа (Боловсрол, шинжлэх ухааны газрын Ахлах мэргэжилтэн)

Р.Солонго (Боловсрол, шинжлэх ухааны газрын боловсролын хяналтын Улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга:

Э.Лхагвадулам (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн Бодлогын хэлтсийн боловсрол хариуцсан мэргэжилтэн)

2.Хяналт шалгалтыг зохион байгуулж 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор дүгнэлт гаргаж, цаашид авах арга хэмжээний саналыг танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Мөнхцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/385

Зуунмод сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант, Баянцагаан, Бүрэн, Дэлгэрхаан, Эрдэнэсант сумдад шинээр гаргасан инженерийн хийцтэй худаг, уст цэгийг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Гантулга (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Гишүүд:

М.Туяа (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)

Б.Баярсайхан (Орон нутгийн өмчийн газрын Ахлах мэргэжилтэн)

Г. Ганбаяр (Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

С.Тулга (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Батболд (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. Шинээр гаргасан инженерийн хийцтэй худгийн сумдын Засаг даргын тамгын газарт хүлээлгэж өгөхийг ажлын хэсэг (Н.Гантулга)-т үүрэг болгосугай.

3. Ашиглалтад хүлээлгэн өгсөн инженерийн хийцтэй худгийг малчдад гэрээгээр эзэмшүүлэх, усны мэдээллийн санд бүртгэж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123011121



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/386

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зуунмод сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 5 нэгж талбарт газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангах, төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Г.Сурмаа (Засаг даргын орлогч)

Гишүүд:

Б.Насанжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Ч.Сарангэрэл (Зуунмод сумын Засаг дарга)

Д.Алтансүх (Аймгийн ерөнхий архитектур бөгөөд барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Д.Сэдэд (Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Г.Баярсайхан (Зуунмод сумын газрын даамал)

Нарийн бичгийн дарга:

Б.Батбаяр (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

2.Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулах Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын шаардлагыг дагаж мөрдөн зохион байгуулах, энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123011010
My.Doc.zahiranj 2023-2 uliral



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/393

Зуунмод

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолын 3, 4 дэх бүлгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар Зуунмод суманд нийтийн тээврийн үйлчилгээнд тээвэрлэлт хийх зориулалтаар худалдан авч байгаа 2 ширхэг том оврын автобусыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Насанжаргал (Төв аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд:

Н.Аасүрэн (Төв аймгийн автотээврийн төвийн дарга)
Б.Рэнчинноров (Төв аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Авто тээврийн хяналтын Улсын байцаагч)
Ч.Сарангэрэл (Төв аймгийн Зуунмод сумын Засаг дарга)
Б.Болормаа (Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн)
Б.Баярсайхан (Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын Ахлах мэргэжилтэн)
Ц.Түвшинжаргал ("Жойнт актив" ХХК-ийн захирал)

2. Олон нийтийн өмчид бүртгэлээр авах.

3. Өмч бүртгэлд бүртгэн, Зуунмод хотын нийтийн тээврийн үйлчилгээнд ариг гамтай ашиглан, нийтийн тээврийн үйлчилгээг чанартай хүргэхийг Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл)-д даалгасугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавихыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123011017
My.Doc.zahiramj 2023-2 uliral



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/394

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2022 оны А/540 дүгээр "Журам шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралтаар баталсан "Оюутан элсүүлэх журам"-ын 4 дүгээр зүйл, Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2023 оны "Элсэлтийн ерөнхий шалгалтын журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв аймагт 2023 оны элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Мөнхцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Мэдээллийн технологи хариуцагч:

Н.Эрдэнэболд (Боловсрол, Шинжлэх ухааны газрын цахим технологи мэдээллийн сүлжээ хариуцсан мэргэжилтэн)

2023 оны элсэлтийн ерөнхий шалгалтын комиссын гишүүн

Сэдэв хариуцагч:

2023 оны элсэлтийн ерөнхий шалгалтын комиссын гишүүн

Гишүүд:

Ц.Нарантуяа (Боловсрол,Шинжлэх ухааны газрын дарга)

С.Мөнхтуяа (Эрүүл мэндийн газрын дарга)

Ч. Сарангэрэл (Зуунмод сумын Засаг дарга)

Э.Лхагвадулам (Нийгмийн бодлогын хэлтсийн боловсролын бодлого хариуцсан мэргэжилтэн)

Г.Солонго (Боловсрол, Шинжлэх ухааны газрын хяналтын Улсын байцаагч)

С.Цэдэндорж (Аймгийн Цагдаагийн газрын хүүхдийн асуудал хариуцсан Ахлах байцаагч)

Л.Эрдэнэцэцэг (Хүмүүн цогцолбор сургуулийн захирал)

Нарийн бичгийн дарга:

2023 оны элсэлтийн ерөнхий шалгалтын комиссын гишүүн,

Б.Дашцэрмаа (Боловсрол,Шинжлэх ухааны газрын судлагдахуун хариуцсан Ахлах мэргэжилтэн)

4123011025
My.Doc.zahiramj 2023-2 uliral

2.Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/540 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Оюутан элсүүлэх журам”-ын дагуу элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахыг ажлын хэсэг (Д.Мөнхцэцэг)-т, элсэлтийн үйл ажиллагаа зохион байгуулах байр, нөхцөл боломжоор хангахыг Боловсрол, Шинжлэх ухааны газар (Ц.Нарантуяа)-т, элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөөр сумдаас ирсэн сурагчдыг Зуунмод сумын сургууль, дотуур байранд байрлуулахыг Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл)-д, шалгалтын үеэр эрчим хүчний хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг УБЦТС ТӨХК хэрэглэгчдэд үйлчлэх төв (А.Өнөржаргал)-д, сахилга, дэг журмын зөрчил гарахаас урьдчилан сэргийлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг)-т тус тус үүрэг болгосугай.

3.Аймагт элсэлтийн ерөнхий шалгалтыг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 18-ны өдрүүдэд зохион байгуулж, дүнг танилцуулахыг элсэлтийн ерөнхий шалгалтын ажлын хэсэг (Д.Мөнхцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д МӨНХБААТАР



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/395

Зуунмод

Газрын зөрчил арилгах талаар
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.13 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.5, 20 дугаар зүйлийн 20.2.2, 23 дугаар зүйлийн 23.3.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.4, 56 дугаар зүйлийн 56.5, 57 дугаар зүйлийн 57.3, 57.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зуунмод хотын оршин суугч иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, нийтийн эзэмшлийн зам, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, газрын зөрчил арилгах, газар чөлөөлөх байршлыг хавсралт ёсоор баталсугай.

2.Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад даалгасугай.

2.1.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж, нийтийн эзэмшлийн зам, талбайд зөвшөөрөлгүй байршуулсан, хавсралтад заасан байршилд газрын зөрчил арилгах, газар чөлөөлөх ажлыг зохих хууль журмын дагуу зохион байгуулж, иргэдийн төлөөллөөс байлцуулахыг Газар чөлөөлөх ажлын хэсгийн дарга Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

2.2.Газрын зөрчил арилгах, газар чөлөөлөх ажилд дэмжлэг үзүүлж, хэв журам сахиулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Д/х Ч.Алтанхуяг)-т;

2.3.Газрын зөрчил арилгах, газар чөлөөлөхөөр батлагдсан байршлуудад хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу зураг төслийг боловсруулж, хэрэгжүүлж ажиллахыг аймгийн ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалтын хэлтсийн дарга (Д.Алтансүхэд);

2.4.Газрын зөрчил арилгах, газар чөлөөлөх ажилд шаардлагатай техник хэрэгслээр хангах, шаардагдах зардлыг төсвөөс санхүүжүүлж ажиллахыг Зуунмод сумын Засаг дарга бөгөөд Хотын захирагч (Ч.Сарангэрэлд);

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР

4123011027
My.Doc.zahramj 2023-2 uliral

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 08 -ны өдрийн 4785 дүгээр
захирамжийн хэвсрэлт

ГАЗАР АЛБАДАН ЧӨЛӨӨЛӨХ ЖАГСААЛТ

№	Овог	Нэр	Регистрийн дугаар	зориулалт	Хаяг	Хэмжээ /м2/	Нэгж талбар	Тайлбар
1.	Батмөнх	Нямдорж	НГ85092170	Авто машины засвар, үйлчилгээний газар	5-р баг стадионы баруун талд	500	4110061974	АЗД-ын 2022.12.30 А/785 захирамжаа р хүчингүй болсон.

___оОо___



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/396

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.7, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Хүүхдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнүүд 2023 оны 06 дугаар сарын 19-28-ны өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулагдах тул спортын 15 төрлөөр 118 хүний бүрэлдэхүүнтэй оролцуулсугай.

2. Хүүхдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнд Төв аймгаас оролцох баг тамирчдыг ахлах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Д.Алтанхуяг (Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга)

Гишүүд

Г.Пүрэвжаргал (Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар)

Б.Оюунбилэг (Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар)

Л.Энхбаяр (Аймгийн Биеийн тамир, спортын газрын Ахлах дасгалжуулагч)

(Спорт холбоодын тэргүүн нар)

Нарийн бичиг:

А.Хажидмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

3. Монголын Хүүхдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнүүдэд баг тамирчдын бэлтгэл зохион байгуулалтыг сайтар ханган амжилттай оролцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Алтанхуяг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/400.

Зуунмод

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг
дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг
2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 3,500,000 (гурван сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

3.Нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайлан мэдээг заагдсан хугацаанд ирүүлэн ажиллахыг агентлагийн дарга, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 13 -ны өдрийн 41400 дүгээр
захирамжийн хавсралт

БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙГ 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго	Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлнэ.							
Үр нөлөө	Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх иргэдийн эрх зүйн ухамсар дээшилнэ.							
Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа	Төсөв (мян. төг)	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Зорилт Нэг.Бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.								
1.1	Хууль зүйн туслалцааны төвийн Төв аймаг дахь салбартай хамтран зорилтод бүлгийн иргэдэд хуулийн мэдлэг олгох эрх зүйн анхан шатны сургалт зохион байгуулж, зөвлөгөө, мэдээлэл өгөх.	Сургалт зохион байгуулах	Зуунмод, Батсүмбэр, Заамар сумдын иргэдэд зохион байгуулж, эрх зүйн зөвлөгөө өгсөн байна	Зорилтод бүлгийн иргэд чиглэгдсэн сургалт зохион байгуулагдсан байна	2,3 улиралд	-	Хууль зүйн туслалцааны төвийн Төв аймаг дахь салбар	ХЭЗХэлтэс
1.2	Эрх зүйн хөтөч нарыг хууль тогтоомжийн эмхтгэл гарын авлагаар хангах.	Гарын авлага	Хэрэгцээ, шаардлагад нийцсэн гарын авлагаар хангасан байна	Эрх зүйн хөтчийн үйл ажиллагаа явуулах боломж хангагдсан байна	Жилийн турш	500,0	ХЭЗХэлтэс	Сумдын ЗДТГ
1.3	Иргэн бүрийн мэдвэл зохих хууль тогтоомж, эрх зүйн актын гарын авлага материал бэлтгэх, сум багийн иргэдэд хүргэх.	Гарын авлага	Хэрэгцээ, шаардлагад нийцсэн гарын авлагаар хангасан байна	Гарын авлага материал бэлтгэн иргэдэд хүргэнэ	Жилдээ	500,0	ХЭЗХэлтэс	Сумдын ЗДТГ

Зорилт Хоёр. Шаардлагатай техник, санхүү, хүний нөөцийг бүдүүлж, тогтсон мэдээллийн сувгуудыг бий болгон тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.									
Эрх зүйн хөтчийн буланг идэвхтэй ажиллуулах.	Мэдээлэл	Иргэдийн эрх зүйн мэдээлэл авах боломж бүрэн бүрдсэн байна	Иргэдэд мэдээллийг шуурхай хүртээмжтэй байдлаар хүргэнэ	Жилийн турш	-	ХЭЗХэлтэс	-		
2.1									
2.2	Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны шторк, контент бэлтгэж олон нийтэд түгээх.	Сургалт сурталчилгааны бүтээгдэхүүн шторк, контент	Хэрэгцээ шаардлагад нийцсэн байна	Иргэдийн эрх зүйн боловсрол дээшилнэ	Жилийн турш	Боловсрол, шинжлэх ухааны газар, ЕБС, Цэцэрлэгүүд	500,0	ХЭЗХэлтэс	ХЭЗХэлтэс
2.3	Хууль зүйн подкаст бэлтгэж, олон нийтэд түгээх.	Подкаст бэлтгэж, олон нийтэд түгээсэн байна			Жилийн турш		-	ХЭЗХэлтэс	Сумдын ЗДТГ
2.4	Эрх зүйн анхан шатны зөвлөгөөг тусгай дугаарын утсаар өгөх үйлчилгээг үзүүлэх.	Утсаар өгөх зөвлөгөө	Эрх зүйн тусламцааны хүртээмж сайжирсан байна	Иргэдэд эрх зүйн тусламцаа, үйлчилгээг шуурхай авна	Жилийн турш	Аймгийн ЗДТГ ХЭЗХэлтэс		ХЭЗХэлтэс	Сумдын ЗДТГ эрх зүйн хөтөч нар
Зорилт Гурав. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд нийгмийн бүх талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна.									
3.1	Эрх зүйн хөтөч бэлтгэх, давтан сургах сургалтыг цахим болон танхим хосолсон хэлбэр зохион байгуулах.	Сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан эрх зүйн хөтчийн тоо	Эрх зүйн хөтчийн сургалт зохион байгуулагдсан байна	2,3 улиралд	ХЭЗХэлтэс	2,000,0	ХЭЗХэлтэс	ХЗҮХ
3.2	Ерөнхий боловсролын болон хүүхдийн өөрөө удирдах байгууллагын гишүүн хүүхдүүдэд "Ялгаварлан гадуурхалт ба дээрэлхэлт" сэдвээр сургалт зохион байгуулах.	Сургалт зохион байгуулах	Сургалтыг зохион байгуулж, зөвлөмж өгч ажилласан байна	Хүний эрхийн ойлголт, хандлага дээшилсэн байна.	Жилдээ	ХЭЗХэлтэс	-	ХЭЗХэлтэс	Сумдын ЗДТГ, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга
3.3	Нотариатын үүрэг гүйцэтгэгч нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах.	Сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан байна	27 сумын Нотариатын үүрэг гүйцэтгэгч нарыг сургалтад хамруулсан байна	2-р улиралд	ХЭЗХэлтэс	-	ХЭЗХэлтэс	-

[illegible]

3.10	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хууль дүрэм журмыг сурталчлах "үе тэнгийн сурагч хүүхэд" "өсвөрийн цагдаа", "Залуу хуульч" зэрэг бүлэг дугуйлан байгуулж, сургаж бэлтгэх	Сургалт зохион байгуулах	Сурагч-сургагч хүүхэд бэлтгэх сургалтыг жил бүр зохион байгуулж, ЕБС бүр 20-оос доошгүй хүүхэд хамруулсан байна.	Сурагчдын эрх зүйн боловсрол дээшлэн ажлын уялдаа холбоо сайжирна.	Жилдээ	-	ХЭЗХэлтэс	Боловсрол, шинжлэх ухааны газар, Сумдын ЗДТГ, ЕБД сургуулиуд
------	---	--------------------------	--	--	--------	---	-----------	--

___оОо___



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/403

Зуунмод

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Зуунмод хотын 9, 10 дугаар байрны хүүхдийн тоглоомын талбайн өндөржилт, явган зам талбайн тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Ганхуяг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

А.Туяажаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн Бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Ц.Нямгарав (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хяналтын инженер)

С.Мөнх-Амгалан (Зуунмод сумын Захирагчийн албаны Ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Э.Номин-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2.Зуунмод хотын 9, 10 дугаар байрны хүүхдийн тоглоомын талбайн өндөржилт, явган зам талбайн тохижилтын ажлын гүйцэтгэгчийг хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Б.Ганхуяг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

1123011050
My.Doc.zahramj 2023-2 ultral



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/404

Зуунмод

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Зуунмод хотын Соёл амралтын хүрээлэнгийн гадна талын тойрог авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

С.Магнайбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

Н.Энхсайхан (Зуунмод сумын Засаг даргын орлогч)

Б.Батбаяр (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

С.Мөнх-Амгалан (Зуунмод сумын Захирагчийн албаны Ахлах
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Г.Тамирмаа (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах
ажиллагааны албаны мэргэжилтэн)

2.Зуунмод хотын Соёл амралтын хүрээлэнгийн гадна талын тойрог авто замын гүйцэтгэгчийг ажлын гүйцэтгэгчийг хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнт танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Б.Ганхуяг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР

1123011051
MyDoc.zalhiramj 2023-2 untral



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/405

Зуунмод

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Зуунмод хотын Соёл амралтын хүрээлэнгийн дотор талын тойрог авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

С.Магнайбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

Н.Энхсайхан (Зуунмод сумын Засаг даргын орлогч)

Б.Батбаяр (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
Газрын удирдлагын хэлтсийн дарга)

С.Мөнх-Амгалан (Зуунмод сумын Захирагчийн албаны Ахлах
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Г.Тамирмаа (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах
ажиллагааны албаны мэргэжилтэн)

2.Зуунмод хотын Соёл амралтын хүрээлэнгийн дотор талын тойрог авто замын гүйцэтгэгчийг ажлын гүйцэтгэгчийг хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Б.Ганхуяг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

129011054
My.Doc.Zahramj 2023-2 ulral



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/112

Зуунмод сум

Зэвсэгт хүчний 016 дугаар
нэгтгэлд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1 дүгээр заалт, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Төв аймагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомж, батлан хамгаалах зарим чиг үүргийг Төв аймагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээний дагуу зэвсэгт хүчний анги нэгтгэл, орон нутгийн батлан хамгаалах үйл ажиллагаанд зориулж Монгол Улсын Маршал Хорлоогийн Чойбалсангийн нэрэмжит Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд 30,000,000 (гучин сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах хөрөнгийг Орон нутгийн хөгжлийн сангийн аймгийн 100 жилийн ойг угтсан бүтээн байгуулалтын болон бусад хандив тусламжийн орлогоос санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт) -т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/456

Зуунмод сум

Нэмэлт ажлын гэрээ байгуулах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөнх алдрын талбайг шинэчлэн засварлах ажилд төв цэгийн боржин чулуун ажлын тоо хэмжээ төсөвт тусгагдаагүй зайлшгүй хийх шаардлагатай байгаа тул нэмэлт ажлын гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. Дээрх нэмэлт ажилд зарцуулагдах 59,925,000 (тавин есөн сая есөн зуун хорин таван мянга) төгрөгийг Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт) нарт даалгасугай.

3. Нэмэлт гэрээг гүйцэтгэгч байгууллагатай байгуулж, чанартай шуурхай зохион байгуулж ажиллахыг Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ (Ж.Баттөгс)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

. 4123011203



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/458

Зуунмод сум

Үер, усны аюулаас
урьдчилан сэргийлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.1, 2.1.5, 3.2, Монгол Улсын Шадар Сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хур борооны улирал эхэлж томоохон гол, нууруудын усны түвшин нэмэгдэж байгаатай холбогдуулан үер, усны аюул, гол усанд хүн осолдохоос урьдчилан сэргийлэх, нэгдсэн арга хэмжээг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2. Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, голомтод үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, иргэд, олон нийтэд сэрэмжлүүлэг, сурталчилгааг шат дараатай зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үер усны аюул, ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээнд шаардагдах 6,456,400 (зургаан сая дөрвөн зуун тавин зургаан мянга дөрвөн зуу) төгрөгийг төсвийн шилжих үлдэгдлийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123011180
My.Doc.zahiranj 2023-2 uliral

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 23-ны өдрийн 4458 дүгээр
захирамжийн 7 дүгээр хавсралт



БОЛЗОШГҮЙ ҮЕР, УСНЫ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, голомтод үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, иргэд, олон нийтэд сэрэмжлүүлэг, сүтэлчилгааг шат дараатай зохион байгуулах гамшгийн эрсдэлийг бууруулах мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэнэ.

Д/д	Хийх ажил	Хугацаа	Хамтран хэрэгжүүлэх
1	Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, шторк бэлтгэж, телевиз, сонин, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сайтаар иргэдэд хүргэх.	Өдөр бүр	Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл
2	Цаг, уурын байгууллагаас үер усны аюулын талаар ирүүлсэн сэрэмжлүүлэг мэдээллийг иргэд, олон нийтэд багц мессежээр дамжуулах.	Өдөр бүр	Онцгой байдлын газар Ус цаг уур, орчны шинэчилгээний газар
3	Иргэдэд үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, сэрэмжлүүлэг тараах.	Өдөр бүр	Онцгой байдлын газар Цагдаагийн газар Сумын Засаг даргын Тамгын газар
4	Хүн ам олноор цуглардаг үйчилгээний газруудад сэрэмжлүүлэг самбар, ухуулах хуудас байршуулах.	06-09 дүгээр сард	Сумын Засаг даргын Тамгын газар
5	Эргийн дагуух явган эргүүл гаргах.	Өдөр бүр	Онцгой байдлын газар Цагдаагийн газар Сумын Засаг даргын Тамгын газар
6	Аймаг, сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх.	07 дугаар сард	Онцгой байдлын газар
7	Үер, усны ослын голомтод үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийн бэлтгэл бэлэн байдалд үзлэг шалгалт хийх.	Сард 2-с доошгүй удаа	Онцгой байдлын газар
8	Завь, аврах хантааз, усны хувцас хэрэгсэлийг нөөцийг нэмэгдүүлэх.	06, 07, дугаар сард	Онцгой байдлын газар, сумын Засаг даргын Тамгын газар
9	Голын ай, сав, гуу жалга, үерийн усны буулт бүхий газраар нутаглаж, суурьшсан айл өрхөд нүүн шилжих тухай шаардах хуудсыг хүргүүлэх.	06-09 дүгээр сард	Сумын Засаг даргын Тамгын газар

10	Голын сав, гуу жалга, үерийн аманд буусан айл өрхийн нүүлгэн шилжүүлэх.	06-09 дүгээр сард	Цагдаагийн газар, Сумын Засаг даргын тамгын газар
11	Үерийн далан, ус зайлуулах шугам инженерийн байгууламжид үзлэг шалгалт зохион байгуулах.	Тухай бүр	Онцгой байдлын газар
12	Үерийн далан сувгийг цэвэрлэж, усны урсацыг чөлөөтэй нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.	06-09 дүгээр сард	Онцгой байдлын газарЗуунмод сумын Засаг даргын тамгын газар
13	Гэр хорооллын айл өрхүүдийн бие засах газар усаар дүүрч халин улмаар орчны бохирдол үүсэж, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх, хяналт тавих.	2023.06.15 2023.09.15	Зуунмод сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Эрүүл мэндийн газар
14	Үер, усны ослоос сэрэмжлүүлэх самбарыг эрсдэл өндөр газруудад байруулах.	06 дугаар сард	Аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын газар, Сумын Засаг даргын тамгын газар
15	Хуучирч муудсан сэрэмжлүүлэг тэмдэг тэмдэглэгээг сэргээх, солих.		
16	Амралт, зугаалгын газруудад үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдэгдэл хүргүүлэх	Өдөр бүр	Сумын Засаг даргын Тамгын газар

АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 23-ны өдрийн 8/458 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

**БОЛЗОШГҮЙ ҮЕР УСНЫ АЮУЛААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

2023 оны 06 дугаар сарын 16

Зуунмод

Нэг. Зорилго

Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, голомтод үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, ард иргэдэд сэрэмжлүүлэг, сурталчилгааг шат дараатай зохион байгуулж, бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах хугацаа

Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулна.

Гурав. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах бүрэлдэхүүн

- 3.1. Онцгой байдлын газар;
- 3.2. Цагдаагийн газар;
- 3.3. Сумдын Засаг даргын Тамгын газар;
- 3.4. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги.

Дөрөв. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний үндсэн чиглэл

- 4.1. Үер усны аюулын голомтод үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах;
- 4.2. Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд сэрэмжлүүлэг сурталчилгааг зохион байгуулах;
- 4.3. Үерийн ус өнгөрүүлэх далан, суваг, нүхэн гарцад үзлэг шалгалт хийх;
- 4.4. Томоохон гол, мөрөн нуур, цөөрөм дагуу эргүүл ажиллуулж, амарч зугаалж буй иргэдэд сэрэмжлүүлэг, мэдээлэл өгөх.

Тав. Урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэх ажил

1. Аймаг, сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх;
2. Аймгийн Гамшгаас хамгаалах албад, сумдын мэргэжлийн ангийн үер, усны аюулын голомтод үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийн бэлтгэл бэлэн байдалд үзлэг шалгалт хийж, шаардлагатай завь, аврах хантаазны нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
3. Голын ай сав, гуу жалга, үерийн усны эрсдэл бүхий газраар нутаглаж байгаа суурьшсан айл өрхөд нүүн шилжих тухай шаардах хуудсыг хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх ажлыг нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
4. Орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагатай хамтран далан суваг, уснэвтрүүлэх нүхэн гарцын хогийг цэвэрлэх, онгойлгох, гэрийг өндөрлөг цэгт бариулах, гэр, хашаандаа шуудуу татуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг эртнээс авах;

5.Усархаг бороо орох үеэр хот хоорондын болон орон нутгийн зорчигч тээврийн хэрэгслийг үер, усны буулт бүхий газраар явуулахгүй байх, шаардлагатай тохиолдолд хөдөлгөөнийг түр хязгаарлах, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, зорчигчдын аюулгүй байдлыг хангуулах, авто вокзалуудад анхааруулга, сэрэмжлүүлэг өгч, хяналт тавьж хамтран ажиллах;

6.Томоохон гол, мөрөн, нуур, цөөрөм дагуусумдын Засаг даргын тамгын газар, Цагдаагийн байгууллага, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн дунд шатны хороотой хамтран эргүүл ажиллуулж, амарч, зугаалж буй иргэдэд сэрэмжлүүлэг, мэдээлэл өгөх;

7.Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг шторк бэлтгэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл цахим сайтаар иргэдэд хүргэх;

8.Иргэд олноор цуглардаг амралт, зугаалгын газар, гол, мөрөн, нуур, цөөрөм, усны осол гарч болзошгүй газруудад үер, уснаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, тэмдэг, тэмдэглэгээ, самбарыг батлагдсан стандартын дагуу 38 ширхэгийг шинээр хийж байрлуулах, хуучирч муудсан тэмдэг, тэмдэглэгээг сэргээх;

9.Иргэд олноор цуглардаг амралт зугаалгын газруудад үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;

10.Ард иргэд, айл өрхүүдэд болзошгүй үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг шат дараатай зохион байгуулах, хүн ам олноор цуглардаг зах, худалдааны төв, үзвэр үйлчилгээний газруудад сурталчилгааны самбар байршуулах, санамж сэрэмжлүүлэг тараах;

11.Бага насны хүүхдийг гол, мөрөн, нуур, тогтоол, устай газар хараа хяналтгүй орхихгүй голын усанд тоглуулахгүй байх, иргэд архидан согтуурсан үедээ голын усанд орохгүй байх талаар сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол өгөх;

12.Үер, усны аюулын үед гэр хорооллын айл өрхүүдийн бие засах газар усаар дүүрч халин улмаар орчны бохирдол үүсэж, халдварт өвчин гарах нөхцөл бүрддэг тул ариутгал, халдваргүйжүүлэлт хийх.

Зургаа . Тайлан мэдээ ирүүлэх, нэгтгэж тайлагнах хугацаа

Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө гаргаж биелэлтийг сар тутам тооцож, тайланг баталгаажуулан аймгийн Онцгой байдлын газарталбан бичгээр ирүүлэх.

АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/164

Зуунмод сум

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх байгаль орчны хяналтын Улсын байцаагч, байгаль хамгаалагч, ойн мэргэжилтэн, мэргэжилтэн нарын хээрийн нөхцөлд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үедээ хэрэглэх үйл ажиллагаанд шаардлагатай өвөл болон зуны нормын хувцсыг шинэчлэн хангах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

А.Зоригоо (Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны албаны дарга)

Гишүүд:

Ц.Очирхуяг (Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын Ойн нэгжийн дарга)

О.Одням (Зуунмод сумын Захирагчийн албаны байгаль орчны мэргэжилтэн)

Г.Тамирмаа (Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Э.Номин-Эрдэнэ (Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны мэргэжилтэн)

2.Байгаль орчны хяналтын Улсын байцаагч, байгаль хамгаалагч, ойн мэргэжилтэн, мэргэжилтэн нарын хээрийн нөхцөлд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үедээ хэрэглэх үйл ажиллагаанд шаардлагатай өвөл болон зуны нормын хувцсыг шинэчлэн хангах ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (А.Зоригоо)-д, ашиг сонирхлын зөрчил авлигаас ангид байх зарчмыг баримтлан зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т, шилэн дансанд мэдээлж ажиллахыг Худалдан авах ажиллагааны алба (А.Зоригоо)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР

4123011179
My.Doc.zahiranj 2023-2 uliral



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/465

Зуунмод сум

“Гэрлээ шилжүүлэ” аяныг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зам тээврийн осол, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд “Гэрлээ шилжүүлэ” аяныг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2.“Гэрлээ шилжүүлэ” аяны зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Аян зохион байгуулагдахад шаардагдах 12,321,340 (арван хоёр сая гурван зуун хорин нэгэн мянга гурван зуун дөр) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

4.Аяныг өндөр хэмжээнд зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Ганхуяг), Төв аймгийн Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг) нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/469

Зуунмод сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зүүн Азийн бүс нутгуудын Аялал жуулчлалын "ЕАТОФ" холбооны 21 дэх удаагийн байнгын хорооны хурлыг 2023 оны 07 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд Төв аймагт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Отгонбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

С.Магнайбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Д.Саран-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

А.Туяажаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ж.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Э.Баярбат ((Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлчилгээний албаны дарга)

Э.Ганхуяг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Төрийн үйлчилгээ, мэдээллийн төвийн Ахлах ажилтан)

Я.Даш-Яйчил (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

М.Цээпил (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Аялал жуулчлал, орчны бохирдол, хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтэн)

А.Батцэцэг (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны хэлтсийн дарга), (зөвшилцсөнөөр)

Г.Дашпүрэв (Аймгийн Аялал жуулчлалын холбооны тэргүүн)

Нарийн бичгийн дарга:

Б.Баярмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

4123011222
МҮ.Бос.замрамж 2023-2 тийм

Б.Хишигдолгор (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

2.Зүүн Азийн бүс нутгуудын Аялал жуулчлалын "EATOF" холбооны 21 дэх удаагийн Байнгын хорооны хурлын төлөвлөгөөг батлуулан бэлтгэл ажлын хурлыг зохион байгуулж, 2023 оны 07 дугаар сарын 05-ны дотор Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Д.Саран-Эрдэнэ)-т даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/478

Зуунмод сум

Агентлаг, харьяа байгууллагуудын
2023 оны эхний хагас жилийн үйл
ажиллагааны үр дүнгийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, аймгийн Засаг даргын 2022 оны А/300 дугаар захирамжаар батлагдсан "Хэлтэс, агентлаг, харьяа байгууллага, сумдын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-ын 11.1, 11.2 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, харьяа байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн эхний хагас жилийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2. Хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээр "А" үнэлгээтэй дүгнэгдсэн байгууллагын даргыг үндсэн цалингийн 40 хүртэлх хувиар, "В" үнэлгээтэй байгууллагын даргыг 30 хувиар байгууллагынхаа төсөвт багтаан шагнаж урамшуулахыг зөвшөөрсүгэй.

3. Салбартаа хийж хэрэгжүүлж буй ажлуудыг иргэдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол тайлагнаж ажиллахыг төсөвт байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Т.Хуягбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/149

Зуунмод сум

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх "Зуунмод сумын Баянхошуу чиглэлийн авто замын шинэчлэлтийн ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Г.Сурмаа (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Г.Хишигдорж (Аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын инженер)

Л.Төр (Аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын инженер)

Н.Энхсайхан (Зуунмод сумын Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Э.Номин-Эрдэнэ (Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2.Зуунмод сумын Баянхошуу чиглэлийн авто замын шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгох ажлын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Г.Сурмаа)-д, ашиг сонирхлын зөрчил, авилгаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зориггоо)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/149 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР

4123011245



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/194

Зуунмод

Газар эзэмших эрх шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль-ийн 66 дүгээр зүйлийн 66.1, Монгол Улсын "Газрын тухай" хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зуунмод сумын Номт 1-р баг Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолборын зориулалттай Сэргэлэнгийн Цэцэнбаяр (РД:СЕ76090812)-ын эзэмшиж байгаа 4110064623 нэгж талбарын дугаартай 8701 м.кв газрыг 3875407 регистрийн дугаартай Арвайн бөгээ ХХК-д 13 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Арвайн бөгээ ХХК (Х.Бат-Эрдэнэ)-д дараах үүргийг хариуцуулсугай.

2.1.Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2.90 хоногийн дотор газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд шилжүүлэн бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн цахим гэрчилгээг <https://egazar.gov.mn/> сайтаар хүсэлтээ илгээж хэвлэж авах.

2.3.Газрын төлөв байдал, чанарын Улсын хянан баталгааг 5 жил тутамд өөрийн хөрөнгөөр хийлгэж байх.

2.4.Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрыг төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.


2.5.Эзэмшиж байгаа газрынхаа эргэн тойронд /50-аас доошгүй метрийн радиус/-ын доторх хог хаягдлыг тогтмол цэвэрлэж, орчноо цэвэр ариун байлгах арга хэмжээ авах.

2.6. Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Насанжаргал), Зуунмод сумын Засаг дарга (Сарангэрэл) нарт тус тус даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн А/638 дугаар захирамжийн холбогдох хэсэг, 031220 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА.



Д.МӨНХБААТАР

4173021290

My.Doc.zahiramj 2023-2 uliral



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/495

Зуунмод сум

Хамтран өмчлөгч хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2007 оны 379 дугаар захирамжаар "Гэр бүлийн хэрэгцээ"-ний зориулалтаар газар хамтран өмчилсөн хамтран өмчлөгч Даваажавын Баттуяа (НА72072168), Ганбаатарын Лхагвадулам (НЮ91091805), Ганбаатарын Лхагвасүрэн (НА93031001), Ганбаатарын Батбаатар (НА98110815) нарыг хамтран өмчлөгчөөс хасч Зуунмод 5-р баг УАА-н 1 дүгээр гудамж 15 тоот хаягт 581м² газрыг Норовын Ганбаатар (ЗЮ68010839)-т үлдээн өмчлүүлсүгэй.

2. Газар өмчлөгч Н.Ганбаатарт дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг үл хөдлөх, эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлж гэрчилгээжүүлэх.

2.2. Газрын төлөв байдал, чанарыг доройтуулахгүй байх.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Б.Насанжаргал), Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл) нарт тус тус даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2007 оны 379 дугаар захирамжид Д.Баттуяа, Г.Лхагвадулам, Г.Лхагвасүрэн, Г.Батбаатар нарт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123011263
My.Doc. zahiramj-3 uliral



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/496

Зуунмод сум

Газрын хэмжээ, хаяг өөрчлөх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 5 дугаар зүйлийн 5.1.5.1, 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв аймгийн Зуунмод сумын Нацагдорж 5-р баг 6-04 дүгээр гудамж 08 тоот хаяг дахь 680м² газар өмчлөгч Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газраа хэмжээг нь өөрчилж, хаяг өөрчлөх өргөдөл ирүүлсэн Батмөнхийн Ууганбаяр (НЮ10231215)-д Нацагдорж 5-р баг Хүрээлэн 307 тоот хаяг дахь 951м² (2,853.000) төгрөгийн үнэ бүхий газрыг үнэ төлбөргүйгээр хуулийн дагуу өмчлүүлсүгэй.

2.Газар өмчлөгч Б.Ууганбаярт ҮҮРЭГ БОЛГОХ нь:

2.1.www.egazar.gov.mn сайтаас кадастрын зургыг хэвлэж авах.

2.2.Газрыг үл хөдлөх, эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлж гэрчилгээжүүлэх.

2.3.Газрын төлөв байдал, чанарыг доройтуулахгүй байх.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Насанжаргал), Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл) нарт тус тус даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны А/40 дүгээр захирамжид Б.Ууганбаярт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123011255



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/497

Зуунмод сум

Нөхөх олговортойгоор сольж
газар өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв аймгийн Зуунмод сумын 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу "Гэр бүлийн хэрэгцээ"-ний зориулалтаар нөхөх олговортойгоор солих газар өмчилж авах хүсэлт гаргасан Жинхүүгийн Тунгалаг (НЮ67050466)-д Номт 1-р баг Жишиг хороолол 2 гудамжны 703 тоот хаяг дахь газрыг байршлыг сольж хуулийн дагуу өмчлүүлсүгэй.

2.Газар өмчлөгч Ж.Тунгалагт ҮҮРЭГ БОЛГОХ нь:

2.1.Газрын кадастрыг мэдээллийн санд оруулж баталгаажуулах.

2.2.Газрыг үл хөдлөх, эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлж гэрчилгээжүүлэх.

2.3.Газрын төлөв байдал, чанарыг доройтуулахгүй байх.

2.4.Ногдуулсан татварыг Ebarimt.mn болон www.egazar.gov.mn сайтаар төлөх.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Насанжаргал), Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/498

Зуунмод

Г Газар эзэмших эрхийн гэрчилгээг Г
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын 1 дүгээр багийн 17 дугаар байрны баруун талд 4110064719 нэгж талбарын дугаартай худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолборын зориулалттай 150м.кв газар эзэмшигч Долгорын Нармандах (ШД61090202)-ын газар эзэмших эрхийн гэрчилгээг Мийгаагийн Энхбаатар (ШЕ68040915)-т шилжүүлэн 3 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч М.Энхбаатар (ШЕ68040915)-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

2.1. Газрыг зориулалтын дагуу эзэмших.

2.2 30 хоногийн дотор газрын кадастрын зураглалыг хийлгэж, мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг egazar.gov.mn цахим системээс авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн, цахимаар ирсэн нэхэмжлэлээр газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/595 дугаар захирамж, 0000047588 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Насанжаргал), Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР

4123010624

My doc:zahiranj 2023-2 uliral. s/maa



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/500.

Зуунмод сум

Хамтран өмчлөгч хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дах заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2004 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 84 дүгээр захирамжаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар хамтран өмчилсөн хамтран өмчлөгч Д.Тэгшзаяа (НЭ99012319), Д.Баярмагнай (НА74050761) нарыг газар хамтран өмчлөгч хасаж 5-р баг Нацагдорж УАА-н 18 байрны 4 тоот 813 мкв газрыг Ц.Дөлбадрах (ШЕ74010614)-д үлдээж үнэ төлбөргүй өмчлүүлсүгэй.

2.Газар өмчлөгч Ц.Дөлбадрах (ШЕ74010614)-д дараах үүргийг хариуцуулсугай.

2.1.Газрыг үл хөдлөх, эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлж гэрчилгээжүүлэх.

2.2.Газрын төлөв байдал, чанарыг доройтуулахгүй байх.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Насанжаргал), Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл) нарт тус тус даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2004 оны 84 дүгээр захирамжийн Д.Тэгшзаяа, Д.Баярмагнай нарт холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

• 4123011271